

“СҮҮ” ХК-ИЙН ТУЗ-ИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2021 оны 07-р сарын 16-ны өдөр

№ 16-1


Улаанбаатар хот

АЖИЛТНУУДАД УРАМШУУЛАЛ ОЛГОХ ТУХАЙ

Компанийн тухай хуулийн 49 дүгээр зүйл, 6 дугаар бүлэг, 76 дугаар зүйлийн 76.1 дэх хэсэг, 80 дугаар зүйлийн 80.2 дахь хэсэг, “Сүү” ХК-ийн дүрмийн 8 дугаар бүлгийн 8.13 дахь хэсэг болон 2021 оны 07 сарын 16-ны өдрийн “Сүү” ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Сүү” ХК-ийн “Үр дүнгийн урамшуулал” олгох журам батлагдсантай холбоотойгоор, журамд заасан болзол, шалгуур хангасан компанийн холбогдох ажилтнуудад улирал бүр компанийн эзэмшлийн халаасны энгийн хувьцаанаас урамшуулал хэлбэрээр олгохыг Гүйцэтгэх захирал /М.Болод/-д зөвшөөрсүгэй.
2. Тогтоолын дагуу ажилтнуудад урамшууллаар олгох халаасны энгийн хувьцааны нөөцийг бүрдүүлэх зорилгоор 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг дуусталх хугацаанд нийт 200,000 ширхэг хүртэлх тооны компанийн хувьцааг зах зээлээс худалдан авахыг Гүйцэтгэх захирал /М.Болод/-д зөвшөөрсүгэй.
3. Ажилтнуудад урамшуулал хэлбэрээр олгох хувьцааны үнийн дүн болон зах зээлээс худалдан авч, халааслах хувьцааны үнийн дүнг “Монголын хөрөнгийн бирж” ТӨХК-ийн тухайн өдрийн зах зээлийн ханшаар тогтоосугай.
4. Энэхүү тогтоолын дагуу компанийн халаасны хувьцааг ажилтнуудад олгохтой холбоотой ажлыг зохион байгуулах, хувьцаа авах эрх үүссэн ажилтнуудын нэрс, тэдгээр ажилтан тус бүрд олгох хувьцааны хэмжээг батлах, түүнтэй холбогдох баримт бичигт компанийг төлөөлөн гарын үсэг зурах, төлбөр тооцоог хийхийг Гүйцэтгэх захирал /М.Болод/-д зөвшөөрсүгэй.
5. Энэхүү тогтоолын дагуу компанийн эзэмшлийн халаасны энгийн хувьцаанаас олгосон хувьцааг хасч, компанийн санхүүгийн данс бүртгэлд тусгахыг Гүйцэтгэх захирал /М.Болод/-д болон Санхүүгийн албаны дарга /Э.Уянга/-д даалгасугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Д.ГАНБААТАР